

ЯПОНЫ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР

Б. Сэржав

Япон улсын «Жижиг дунд үйлдвэрийн хууль»-д зааснаар аж үйлдвэрийн салбарт 100 сая хүртэлх иенийн үндсэн хөрөнгө, 300 хүртэлх байнгын ажиллагсад бүхий үйлдвэрийг; бөөний худалдааны салбарт 30 сая хүртэлх иенийн үндсэн хөрөнгө, 100 хүртэлх байнгын ажиллагсад бүхий пүүс, компанийг; жижиглэн худалдаалах болон үйлчилгээний салбарт 10 сая хүртэлх иенийн үндсэн хөрөнгө, 50 хүртэлх ажилчин бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг жижиг дунд үйлдвэрт хамааруулан үздэг ажээ. Өнөөгийн байдлаар Японы нийт үйлдвэрийн газрын 99,3 хувь, нийт ажиллагсдын 80,6 хувийг жижиг дунд дунд үйлдвэр эзэлж байна. Эдгээр үйлдвэрүүд нь улс ардын аж ахуйн бүхий л салбарт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж, том үйлдвэрүүдтэй харилцан бие биенээ нөхөж оршин тогтнож байдаг юм. Жижиг дунд үйлдвэрийн тухай нэр томъёо нь уг үйлдвэрийн газрын аж ахуйн газрын үйл ажиллагааны цар хүрээ, нийгэм-эдийн засгийн хөгжлийн үе шаттай уялдан жижиг дунд ба том үйлдвэрт харилцан адилгүй үзүүлэлтээр ангилан үздэг ажээ.

Японд үйлчилгээ, жижиглэн худалдаалах салбарт жижиг дунд үйлдвэр ихэнх хувийг эзэлж байна. Мөн нэхмэл, сүлжмэл, хүнс, арьс шир, металл боловсруулах болон барилгын чиглэлийн үйлдвэрүүдийн 80 гаруй хувийг 50 хүртэлх ажиллагсадтай жижиг дунд үйлдвэр эзэлж байна. Жижиг дунд үйлдвэрүүд зөвхөн 1992 онд гэхэд л аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 52,6 хувь түүнээс оюуны багтаамж шингээсэн нийт бүтээгдэхүүний 48,8 хувь, бөөний болон жижиглэн худалдаалах салбарт борлуулсан нийт бараа материалын 62,8 хувийг жижиг дунд үйлдвэрт бүтээн бий болгосон тооцоо гэрчээ.

Жижиг дунд үйлдвэрүүд нь өөрийн гэсэн өвөрмөц технологитой, үйл ажиллагаа, зохион байгуулалт нь маш уян хатан, эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдалд хурдан шуурхай зохицож чаддаг зэрэг онцлог шинжтэй. Японд жижиг дунд үйлдвэрийн том үйлдвэрээс ялгагдах гол ялгаа нь хөрөнгийн болон ажиллах хүчний тоо хэмжээ төдийгүй, бүтэц, зохион байгуулалт, технологийн түвшин зэргээрээ ч ихээхэн онцлог ялгаатай. Том үйлдвэрийн газрууд нь хөрөнгийг асар ихээр төвлөрүүлж, бүтээгдэхүүнийг асар ихээр үйлдвэрлэх онцлоглогтой байхад, жижиг дунд үйлдвэр нь олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг харьцангуй цөөн тоогоор үйлдвэрлэх бүтэцтэй байдаг ажээ. Өөрөөр хэлбэл үйлдвэрийн нэгж газрын тухайд зах зээлийн бага хэмжээний эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн бүтэцтэй боловч маш олон талт үйл ажиллагаа явуулахад богино хугацаанд түргэн зохицох чадвартайгаараа том үйлдвэрээс ялгарах онцлог давуу талтай.

Сүүлийн 10 жилийн хугацаанд улс орны эдийн засгийн хөгжилд гарсан асар их дэвшилд жижиг дунд үйлдвэрийн үүрэг

* Б. Сэржав, ЗХАСТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

роль, нэр хүнд нэртэй томоохон пүүс корпорациудаас ч дутахааргүй байгааг энэ чиглэлийн судалгааны бүтээлүүдэд олон таа тэмдэглэж байна. Үүнийг 80-аад оноос хойш Японы эдийн засагт дараах хэдэн онцлог өөрчлөлтүүд гарсантай нягт холбон үзэж болох юм. Үүнд: —Японы иений ханш 1985 оноос эрс дээшилсэн нь экспортын хэмжээ багасахад нөлөөлж, экспортын чиглэлийн бараа үйлдвэрлэж ирсэн үйлдвэрүүд юуны өмнө дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн үйлдвэрлэл явуулах болсон;

— 80-аад оны сүүл үе нь Азийн шинээр аж үйлдвэржсэн орон, бүс нутгийн эдийн засаг их эрчимтэй хөгжсөн үе бөгөөд эдгээр орон, бүс нутгаас авч буй импортын барааны хэмжээ эрс өссөн нь японы ижил чиглэлийн үйлдвэрүүдэд шинэ өрсөлдөөнийг бий болгосон;

— Эдийн засаг улам бүр олон улсын шинж чанартай болж буй өнөөгийн үйл явцтай уялдан, японы үйлдвэр компаниуд гадаадад өөрийн салбараа олноор байгуулж байна. Тэдгээр үйлдвэр, аж ахуйн газрын үйл ажиллагаа нь урьдын зах зээлийн хүрээнээс хальж, Азийн шинээр аж үйлдвэржсэн орон, бүс нутаг, АСЕАН, цаашлаад хуучин социалист орнууд, Хятад, Вьетнамын зах зээлд өргөнөөр нэвтрэн орж, өөрийн гэсэн тодорхой байр суурь эзлэх боллоо. Энэхүү байр суурь нь ч жилээс жилд улам бэхжиж, тэлэн хөгжсөөр байна.

— Эдийн засаг харьцангуй удаан хугацаагаар тогтвортой хөгжсөн нь ард түмний аж байдлыг улам сайжруулж, дотоодын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ улам олон талтай болж, бараа материалын чанарын өндөр үзүүлэлтийг шаардах болсон;

— Нийт улс ардын аж ахуйд технологийн шинэчлэлт эрчимтэй явагдаж, мэдээллийн үүрэг маш хүчтэй болж ирсэн зэргийг дурдаж болох юм. Улс орны эдийн засагт гарсан эдгээр өөрчлөлтүүдтэй нягт уялдуулан жижиг дунд үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийг хамгийн оновчтой явуулж иржээ. Тухайлбал, Японы жижиг дунд үйлдвэрийн асуудал эрхлэх газраас жил бүр гаргадаг «Жижиг дунд үйлдвэрийн цагаан ном»-д Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ ихсэж, мөнгөний ханш дээшилсний улмаас 1980-аад онд бий болсон эдийн засгийн огцом өөрчлөлтөд жижиг дунд үйлдвэрүүд богино хугацаанд шуурхай, уян хатан зохицож, улс орны бүтцийн өөрчлөлтөд ихээхэн хувь нэмэр орууллаа» гэж тэмдэглэжээ.

Мөн сүүлийн жилүүдэд жижиг дунд үйлдвэрүүд улам олон төрлийн үйлдвэрлэл явуулж, шинэ шинэ салбаруудад идэвхтэй нэвтэрч, ялангуяа хөдөлмөрийн бүтээмж сайтай салбарт шинээр үйлдвэрлэл эрхлэх зэргээр том үйлдвэрүүдээс ч идэвхтэй ажиллаж ирснийг энэхүү Цагаан номд цохон тэмдэглэсэн байна. Ер нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн явцад үйлдвэрүүд салбарынхаа дотоодод үйлдвэрлэлээ өргөтгөх, багасгахаас гадна цоо шинээр үйлдвэр үйлчилгээ эхлэх, эсвэл хуучин үйлдвэрлэлээ зогсоох, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ өөрчилж, шинэ салбарын бүтээгдэхүүн хийх зэрэг үзэгдлүүд нийтлэг байдаг.

Японд жижиг дунд үйлдвэрийн газрууд жилдээ хэдэн ар-

ван мянгаараа шинээр байгуулагдаж, мөн төдий тооны жижиг дунд үйлдвэр үйлдвэрлэлээ зогсоож хаагдаж байх нь жирийн үзэгдэл ажээ. Ер нь жижиг, дунд үйлдвэр төдийгүй нийт эдийн засгийн хэмжээнд хурцаар тавигдаж байгаа нэг асуудал бол ажиллах хүчний дутагдал юм. Харин жижиг дунд үйлдвэрийн хувьд үүнээс гадна урт богино хугацаатай зээлийн өр, үйлдвэрийн хойчийг залгамжлах асуудал бэрхшээлтэй байдаг ажээ. Тухайлбал, 1991 онд 6441 үйлдвэрийн газар дампуурсан нь өмнөх оныхоос 10 хувиар цөөн байжээ. Зөвхөн 1990, 91 онд дампуурсан жижиг дунд үйлдвэрийн газруудад хийсэн судалгаанаас үзэхэд дампуурлын гол шалтгаан нь нэгд, өрийн асуудал; хоёрт, ажиллах хүчин хүрэлцээгүй, хуучин ажиллагсад нь насны тэтгэвэрт гарснаас залгамж халаа дутагдалтай; гуравт, зах зээлийн үнийн өөрчлөлтийг буруу үнэлж, бизнесийн алдаа гаргаснаас болж дампуурсан байна.

Дээрхээс гадна олонхи жижиг дунд үйлдвэр нь хөдөлмөрийн нөхцөлөөр том үйлдвэрийн газрын хэмжээнд хүрдэггүй. Ялангуяа энд ажиллаж буй хүмүүс том үйлдвэрт ажиллагсдаас удаан цагаар ажиллаж, доогуур цалин хөлс авдаг, боловсон хүчний хувьд ч дээд сургуулийг сайн дүнтэй төгсөгчид болон нэртэй том сургуулийг төгсөгчид мөн л нэртэй том пүүс, компаниудад ажилд ордгоос жижиг дунд үйлдвэрт сайн боловсон хүчин төдий л олддоггүй гэх зэрэг бараан ойлголтууд нэлээд түгээмэл байдаг. Ялангуяа том үйлдвэр ба жижиг дунд үйлдвэрийн ажиллагсдын цалингийн ялгаа нь нэлээд анхаарал татсан асуудлын нэг ажээ. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн тогтвортой хөгжилтэй уялдан жижиг дунд үйлдвэрт ажиллагсдын цалин том үйлдвэрийн ажиллагсдын цалинд нэлээд дөхөж очсон байна. Гэвч жижиг дунд үйлдвэрийн хувьд ажиллагсдын боловсрол мэдлэг, ажил мөргөжлийн төрөл зүйл, ажилласан жил зэрэг нь үндсэн цалинд ихээхэн нөлөөлдөг. Дээрх цалингийн ялгаа нь залуучуудын хувьд харьцангуй бага, харин дунд болон ахмад ажилчдын хувьд их байдаг ажээ.

Ялангуяа дээр дурдсан хөдөлмөрийн муу нөхцөлд тогтоосон цаггүй ажилладаг гэх мэтийн сүүдэртэй ойлголт нь шитаүкэ кигио (захиалгат гэрээт үйлдвэр гэсэн утгатай)-д хамаарагдах юм. Эдгээр үйлдвэрүүд нь бусад үйлдвэр, нэртэй том корпорациудаас үйлдвэрлэлийн захиалга авч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байна. Ийм шитаүкэ кигио нь японы нийт жижиг дунд үйлдвэрийн талаас илүү хувийг эзэлж байна. Шитаүкэ үйлдвэрийн энэ систем нь зөвхөн жижиг дунд үйлдвэрийн төдийгүй нийт японы аж үйлдвэрийн онцлог тал гэж судлаачид үздэг юм. Ийм үйлдвэр ялангуяа нэхмэл, сүлжмэл, техникийн эд ангийн төрөлжсөн үйлдвэрүүдийн дотор ихэнх хувийг эзэлдэг.

Эдгээр шитаүкэ үйлдвэрүүд мэргэжлийн маш өндөр ур чадварыг эзэмшсэн байдгийн зэрэгцээ хямд төсөр өртгөөр, чанарын дээд ангиллын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргадаг. Энэ чанараараа ч тухайн үеийн эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцэн зохицсон үйлдвэрлэлийг явуулж чаддагаараа улс орныхоо эдийн засагт чухал нөлөөтэй байр суурь эзэлдэг. Гагцхүү түүний сул тал нь том үйлдвэрийн хэрэгцээ шаардлагын дагуу захиалгыг хүлээн авч бүтээгдэхүүн гаргадаг, тэрхүү за-

хиалга нь хугацаа болон үнийн хувьд захиалагчийн эрх ашигт ихэвчлэн нийцсэн байдгаас жижиг үйлдвэрийн хувьд хохиролтой байх нь олонтаа. Нөгөө талаар жижиг дунд үйлдвэрийн хувьд захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй учир борлуулалтын асуудалд санаа зовохгүй тал ч бас байдаг байна. Жижиг дунд үйлдвэргүйгээр том үйлдвэр оршиж чадахгүй тийм үйлдвэрлэлийн систем нэгэнт бүрэлдэж тогтсон гэж судлаачид үздэг ажээ. Үнэхээр ч дотооддоо төдийгүй дэлхийд дээгүүр байр эзэлдэг японы том том корпорациуд ихэвчлэн доороо маш олон шитаүкэ үйлдвэртэй байж, том үйлдвэрүүд шаардлагатай үед тэдэнд захиалга өгч өөрийн хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг хийлгэдэг байна.

Нөгөө талаар жижиг дунд үйлдвэр нь санхүүжилтийн хувьд том үйлдвэр компанитай харьцуулахад нэлээд бэрхшээлтэй, ялангуяа гаднаас санхүүжилт авахад хүндрэлтэй асуудал нэлээд тулгардаг. Жижиг дунд үйлдвэрийн хувьд үнэт цаасны зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх асуудал хязгаарлагдмал, санхүүгийн байгууллагаас мөнгөн зээллэг авахад ч хүндрэлтэй. Яагаад гэвэл, аж ахуйн талаар тогтвортой бус, риск ихтэй, нөгөө талаар барьцаалах хөрөнгөөр дутмаг байдаг. Жижиг дунд үйлдвэрийн тоо нь олон, тус тусын үйлдвэрт шаардагдах тхөрөнгийн хэмжээ их биш боловч санхүүжилт хийх нийт зардал их болдог зэрэг хүндрэл байдаг байна.

Аж ахуйн үйл ажиллагаа нь тогтвортой, барьцаалах эд хөрөнгөтэй жижиг дунд үйлдвэрийн тухайд ч банк, санхүүгийн байгууллагын зүгээс хөхүүлэн дэмжих асуудалд ихээхэн хойрго ханддаг байна.

Санхүүгийн эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд Японд жижиг дунд үйлдвэрүүдийн санхүүжилтэд туслах зорилготой Зээлийн сан, Зээлийн нэгдэл зэрэг санхүүгийн хувийн байгууллагууд ажилладаг. Эдгээр нь жижиг дунд үйлдвэрүүдийг гишүүнээ болгож нэгдлийн зохион байгуулалтад үндэслэн, жижиг дунд үйлдвэрийн хүрээнд хөрөнгө бий болгож, түүнийгээ хөрөнгө дутагдалтай байгаа гишүүддээ олгох зорилготой ажээ. Зээл, санхүүжилтийн хувийн байгууллагууд нь нэгдлийн зохион байгуулалттай хэдий боловч Зээлийн сангуудад гишүүн бус үйлдвэрээс ч хадгаламж авдаг байна. 1990 оны байдлаар 454 зээлийн сан (гишүүн нь 7 сая 260 мянган жижиг дунд үйлдвэр), 414 зээлийн нэгдэл (гишүүн нь 3 сая 790 мянган үйлдвэр) ажиллаж байв.

Хувийн эдгээр байгууллагуудын хүчээр жижиг дунд үйлдвэрүүдийн санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэх боломжгүй учир Засгийн газар төрөл бүрийн арга хэмжээ авч жижиг дунд үйлдвэрийг дагнан санхүүжүүлэх байгууллага, Иргэдийг санхүүжүүлэх сан (Кокумин кинюү кайко), Жижиг дунд үйлдвэрийг санхүүжүүлэх сан (Чюүшөо кигио кинюү кайко), Худалдаа үйлдвэрийн нэгдлийн төв сан (Шёоко күмиай чюүо кинко) зэргийг байгуулан ажиллуулж байна. Түүнээс гадна барьцаалах хөрөнгө хомс жижиг дунд үйлдвэрүүдэд зээлийн баталгаа гаргах нийгэмлэг (Шинёо хошо киокай), жижиг дунд үйлдвэрийн зээлийн даатгалын сан (Чюүшөо кигио шинёо кокэн кайко) гэх мэтийн улсын байгууллагууд байдаг.

Дайнаас хойших эдийн засгийн эрчимтэй хөгжлийн жилүү-

дэд Японд жижиг дунд үйлдвэрийг улс орны эдийн засагт идэвхтэй байр суурьтай, биеэ даасан томоохон хүчин болж хөгжихөд төрөөс явуулсан бодлого их нөлөөлжээ. Японы жижиг дунд үйлдвэрийн газрын хуульд жижиг дунд үйлдвэрийн талаар төрөөс явуулах бодлогын чиглэлийг тодорхойлохдоо: «Жижиг дунд үйлдвэрийн улс орны эдийн засагт гүйцэтгэж байгаа үүрэг ролийг харгалзан тэдгээрийн эдийн засаг, нийгмийн нөхцөлийг сайжруулж, үйлдвэрийн орлого, цалин, хөдөлмөрийн бүтээмжийн том үйлдвэрээс ялгарах ялгааг арилгах гэсэн хүчин чармайлтыг нь дэмжиж үйлдвэрүүдийг хөгжүүлэх, ажиллагсдынх нь байр суурийг дээшлүүлэхэд төрөөс ихээхэн анхаарал халамж тавих явдал» гэжээ. Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, эдийн засагт монополийг хориглох, жижиг дунд үйлдвэрийн менежментийг зохистой хэмжээнд хүргэх, үйлдвэрүүдийг нэгдмэл хамтын ажиллагаатай байлгах, үйлдвэрүүдийн хоорондын уялдаа холбоо харилцааг сайжруулах зэрэг арга хэмжээг авсан байна. Мөн жижиг дунд үйлдвэрүүдийн бүтцийг сайжруулах, ялангуяа шитаүке зохион байгуулалттай худалдааны болон уламжлалт гар урлалын чиглэлийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байна.

Жижиг дунд үйлдвэрийн талаарх төр засгийн энэхүү бодлого нь дотоодын аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтийн бодлоготой нягт уялдаатай явж ирсний зэрэгцээ олон улсын зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад зохицсон, чөлөөт шударга өрсөлдөөнийг дэмжих зарчмыг баримталж олон улсын хэмжээнд үндэснийхээ аж үйлдвэрийн хөгжлийг уялдуулан зохицуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн цогцолбор арга хэмжээний нэг хэсэг юм. Жижиг дунд үйлдвэрийн ирээдүйн хөгжлийн үүднээс нэгд, том үйлдвэртэй харьцуулахад байр суурийн хязгаарлагдмал талыг даван туулж, чөлөөтэй өрсөлдөх нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх; хоёрт, жижиг дунд үйлдвэрүүдийн мэргэжлийн болон оригинальн чанарыг давуутай хөгжүүлж, зүй зохисгүй өрсөлдөөнийг хязгаарлах; гуравт, үйлдвэрлэл технологийн нөхцөлөөс урган гарсан үйлдвэр хоорондын өвөрмөц төрлийн худалдаа, хөдөлмөр хуваарилалтыг дээд шатанд дэвшүүлэх, мэдээллийн сүлжээг улам сайжруулахад төрөөс дэмжиж өгүүштэй байгааг Японы жижиг дунд үйлдвэрийн газраас нийтлүүлсэн «90-ээд оны жижиг дунд үйлдвэрийн дүр төрх» номонд дурджээ.

Жижиг дунд үйлдвэрийн хуульд зааснаар жижиг дунд үйлдвэрийн талаар төрөөс явуулах бодлого нь монопольт капитализмын нөхцөлд том үйлдвэрүүдийн түргүүлэх байр сууринаас хамааран жижиг дунд үйлдвэрүүдийн өмнө тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэн зохицуулж, өрсөлдөх чадал, хөгжих боломж чадавхи бүхий үйлдвэрүүдийг бий болгож улс ардын аж ахуйн эрх ашгийн үүднээс эдийн засгийг зүй зохистой чиглэлээр хөгжүүлэх зорилготой ажээ. Ер нь жижиг дунд үйлдвэрийн талаархи бодлогыг эдийн засагт цаашид бий болж болзошгүй монополиос сэргийлэх бодлоготой ямагт салшгүй холбоотойгоор авч үзэж хөгжүүлдэг байна.

Японы эдийн засгийн төлөвлөлтийн газраас гаргасан «2000 оны Япон» хэмээх номонд жижиг дунд үйлдвэрийг нэгд, том

үйлдвэрийн хэмжээнд өсч хөгжих ирээдүйтэй үйлдвэрүүд; хоёрт, зах зээлийн шинэ чанараас авч үзэхэд цар хэмжээгээр боломжийн үйлдвэрүүд; гуравт, эдийн засгийн талаасаа олон тооны тулгамдсан асуудал бүхий үйлдвэрүүд хэмээн хувааж тус бүрийн онцлогт тохируулан эхний хэсэг үйлдвэрийн хувьд цаашид бэхжүүлж хөгжүүлэх, хоёрдахь хэсгийн хувьд аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлтөд зохицуулан хөгжүүлж дэмжих, эдийн засгийн хувьд оршин тогтноход хүндрэлтэй гэж үзэж буй гуравдахь хэсэг үйлдвэрийн хувьд гаднын алив нөлөөнөөс хамгаалах бодлогыг төрөөс явуулах нь зүйтэй гэж үзжээ. Японы жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн өнөөгийн байдлаас тоймчлон өгүүлэхэд ийм байна.

Ашигласан ном зохиол

— «Чюүшёо кигио хакушё Хэйсэй 3 нэнбан» (Жижиг дунд үйлдвэрийн цагаан ном. Хэйсэн 3 он хэвлэл), Токио, 1992.

— Ёшитани Изүми «Нихон—но чюүшёо кигио» (Японы жижиг дунд үйлдвэр), Токио, 1992.

— «Кэйзай гаку житэн» (Эдийн засгийн толь бичиг), Токио, 1992.

— «Нихон кэйзай зүсэцү» (Японы эдийн засгийн график, тайлбар), Токио, 1989.

— «Кэйзай хакушё, Хэйсэй 6 нэнбан» (Эдийн засгийн цагаан ном Хэйсэй 6 он), Токио, 1995 он.

— «Чюүшёо кигио кихо» (Жижиг дунд үйлдвэрийн улирлын мэдээ) сэтгүүл, 1980—1992 оны дугаарууд.

— «Кэйзай шихио—но кандокоро» (Эдийн засгийн үзүүлэлтийн гол тойм), Теояма кэн. 1990.

— «90 нэндай—но чюүшёо кигио бижюон» (90-ээд оны жижиг дунд үйлдвэрийн дүр төрх), Токио, 1990.